



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 05/19

Жаргалтхаан сум

**Э.Эрдэнэхүүд ажил хавсран
гүйцэтгүүлэх тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга Энхбатын Эрдэнэхүүд Санхүүгийн албаны Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Засаг даргын Тамгын газар хариуцсан нягтлан бодогчийн албан үүргийг хавсран гүйцэтгүүлсүгэй.

2.Э.Эрдэнэхүүд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

3.Нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтонд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Э.Эрдэнэхүүд үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГАНБАТ